



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Иргэний эрх зүйн маргаан¹)

"PUBG MOBILE" ТОГЛООМЫН ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЛИЙГ ХУДАЛДАН АВАХАД НАСАНД ХҮРСЭН БАЙХ ЭСХҮЛ АСРАН ХАМГААЛАГЧИЙН ЗӨВШӨӨРЛИЙГ АВСАН БАЙХ ШААРДЛАГАТАЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2024/00316

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 12 сарын 17-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Хяналтын шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, нэхэмжлэгч нарын гомдлын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Г.Э нь PUBG тоглоомын эрхийг авч өгөх, хамтарч тоглох, үүний төлөө урамшуулал авах нөхцөл бүхий гэрээний саналыг нийтэд илэрхийлсэн. Түүний ажиллуулдаг пэйж хуудсаар дамжуулан Х.С-н хүү С.Т нь PUBG тоглоомын эрх авах хүсэлт гаргаж, нэхэмжлэгч Х.С-н охин С.Н-н эзэмшлийн данснаас хариуцагч Г.Э-н эзэмшлийн дансанд хэд хэдэн удаагийн гүйлгээгээр нийт 35,138,605 төгрөг шилжүүлсэн, уг мөнгийг нэхэмжлэгчийн төрсөн хүү С.Т түүний гар утсаар интернэт банкаар шилжүүлсэн, хариуцагч 5,060,000 төгрөгийг буцаан өгсөн байна.

Нэхэмжлэгч Х.С, хариуцагч Г.Э-д холбогдуулан үлдэх 30,078,605 төгрөг гаргуулах нэхэмжлэлийн үндэслэлээ "...Г.Э нь насанд хүрээгүй хүүхэдтэй эцэг, эхийн зөвшөөрөлгүй хэлцэл байгуулсан нь хүчин төгөлдөр бус хэлцэл болох буюу их хэмжээний мөнгө шилжүүлж байгаа тохиолдолд насанд хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг, шалгаагүй буруутай..." гэж,

Хариуцагч татгалзлын үндэслэлээ "...Тоглоомын эрхийг авч өгөхдөө тухайн хүний царайг харах боломжгүй, хандсан хүнд нь авч өгдөг. С.Т-г насанд хүрээгүй гэж мэдээгүй. С.Т өөрөө төлбөрөө төлж тоглоомын эрх авсан. 30,078,605 төгрөг нь тоглоомын эрх худалдан авсан төлбөр ба надад энэ мөнгө үлдээгүй тул нэхэмжлэлийг зөвшөөрөхгүй..." гэж тус тус маргажээ.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:
https://shuukh.mn/single_case/10721?daterange=2024-12-17%20-%202024-12-17&id=3&court_cat=1&bb=1



ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- 1. Анхан шатны шүүхээс** нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн ба “Нэхэмжлэгч Х.С насанд хүрээгүй хүү С.Т-н бусадтай хийсэн хэлцлийн үр дагаврыг хариуцах үүрэгтэй...”, PUBG MOBILE тоглоомын эрхийг олон улсын байгууллагаас худалдан авч өгөх үйл ажиллагааг хуулиар хориглоогүй байхаас гадна энэ төрлийн үйл ажиллагааг явуулахдаа үйлчлүүлэгчийн насны хязгаарыг тогтоосон журам батлагдаагүй байна..., тоглоомын эрхийг авахдаа цахимаар харилцаж авдаг, дүрсээ хардаггүй, биеийн байцаалттай холбоотой бичиг баримтыг тодруулах буюу насанд хүрсэн эсэхийг мэдэх боломжгүй байна. Нэхэмжлэгчийн өөрийн буруутай үйлдэл нөлөөлсөн..., хариуцагч Г.Э уг мөнгөн хөрөнгийг өөртөө олж аваагүй тул Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д заасан үндэслэл тогтоогдоогүй” гэсэн дүгнэлтийг хийсэн байна.
- 2. Давж заалдах шатны шүүх** хариуцагчаас 752,825 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгч Х.С-д олгож шийдвэрлэхдээ “цахим тоглоом нь хуулиар хориглогдоогүй, гэрээг байгуулах үед зохих этгээдээс зөвшөөрөл авах ёстой байсан нөхцөл байдал тогтоогдоогүй тул талуудын байгуулсан гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэлгүй..., цахим тоглоомын эрхийг нэхэмжлэгчийн хүү хүлээн авсан, уг мөнгө хариуцагчид үлдээгүй байх тул энэ мөнгөн дүнгээр хариуцагчийг үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж дүгнэхгүй, давж заалдах шатны шүүх хуралдаанд хариуцагч нь 752,825 төгрөгийг нэхэмжлэгчид буцаан төлөх боломжтой болохоо илэрхийлсэн тул энэ хэмжээгээр нэхэмжлэлийг хангаж, шийдвэрт өөрчлөлт оруулав...” гэжээ.
- 3. Хяналтын шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ:** Хариуцагч Г.Э-н PUBG MOBILE тоглоомын эрхийг олон улсын байгууллагаас худалдан авч, уг тоглоомын эрхийг бусдад дамжуулсан үйл ажиллагаа нь нэг удаагийн шинжтэй, уг үйлдлийг хууль бус гэж үзэх үндэслэл хэрэгт байгаа баримтын хүрээнд тогтоогдоогүй, зохигчийн хооронд үүссэн тохиролцоог хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлгүй хэдий ч ийм үйл ажиллагааг **ашиг олохын тулд тогтвортой эрхлэх нь хууль бус шинжийг агуулах боломжтойг дурдах нь зүйтэй** гэж үзэв. Учир нь тус тоглоомын тухайд насанд хүрээгүй хүүхэд тоглох боломжийг хязгаарласан байдгаас гадна, насанд хүрээгүй хүүхдүүд эцэг эхийн зөвшөөрөлгүй хийсэн мөнгөн төлбөрийн зарцуулалтыг хянахад чиглэсэн дүрмүүд, хэрэглэгчийн эрх болоод тоглоомын зохион бүтээгч компанийн хариуцлага зэргийг илүү тодорхой болгосон журам, зааварчилгаа байдаг учраас **тоглох эрхийг дамжуулах, зуучлах үйл ажиллагааг явуулах нь хууль бус болно.** (12)²
- 4. Тоглогч болох С.Т нь насанд хүрээгүй, түүний хууль ёсны төлөөлөгч Х.С нь түүний Г.Э-тай байгуулсан “PUBG MOBILE” тоглоом тоглох эрх худалдан**

² Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно



авсан хэлцлийг дэмжээгүй нь Иргэний хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1³, 54.2⁴-т зааснаар дамжин хуулийн 56.1.1⁵-д зааснаар хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлийг бий болгож болох боловч Г.Э нь 30,078,605 төгрөгийг өөртөө аваагүй, тоглоомын эрхийг цэнэглэсэн, үүнийг нь С.Т захиран зарцуулсан учир Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1⁶-д заасан үндэслэл байхгүй гэж үзсэн хоёр шатны шүүхийн дүгнэлт хууль зөрчөөгүй. Гагцхүү хоёр шатны шүүх “хариуцагч гэм буруутай үйлдлээр хохирол учруулсан” гэсэн гэм хорын эрх зүйн шаардах эрх давхар агуулсан байгааг анхаараагүй нь учир дутагдалтай болсон байна.

5. “PUBG MOBILE” тоглоомын төлбөр төлөх цэс рүү хандахад “midasbuy” гэх гуравдагч платформыг холбосон байх ба үүний хэрэглэх нөхцөлд “18-аас доош /эсхүл тухайн улсын хуулиар насанд хүрээгүй хэмээн тооцогдох/ настай бол таны эцэг эх, эсхүл асран хамгаалагч энэхүү нөхцөлийг урьдчилан хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай”, “ямар нэг бүтээгдэхүүнийг худалдан авахаар захиалга хийсэн тохиолдолд та бидэнд өөрийн данснаасаа төлбөрийг татах эрхийг олгож байгаа ба ийнхүү худалдан авалт хийх санаа зорилгогүй байсан зэрэг тохиолдолд ч буцаалт хийгдэх боломжгүй”, “Бид ямар нэгэн гуравдагч этгээдийн шаардаж буй төлбөрийг хариуцахгүй” гэж заажээ. (14.1)
6. Ийнхүү хориглосон агуулга бүхий нөхцөл, анхааруулгыг тоглоомын хэрэглэгчийн зүгээс зайлшгүй уншиж танилцан, зөвшөөрснөөр цахим хэлцэл байгуулагддаг байхад хариуцагч Г.Э нь энэ талаар тоглогчийн эрхийг эдлүүлээгүй, тоглогч нь насанд хүрсэн эсэх, эцэг эх эсхүл асран хамгаалагч нь зөвшөөрсөн эсэхийг шалгаагүй, уг тоглоомыг тоглох үр дагавар сөрөг нөлөөтэй болохыг анхаараагүй нь хариуцагчийг гэм буруутай гэж үзэх үндэслэл болно. Өөрөөр хэлбэл, хариуцагчийн хууль бус үйлдлийн улмаас нэхэмжлэгчид эд хөрөнгийн хохирол учирсан шалтгаант холбоо байгаа учир Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1⁷, 510 дугаар зүйлийн 510.1⁸-д зааснаар шаардах эрхтэй гэж үзнэ.
7. Иргэний хуулийн 514 дүгээр зүйлийн 514.1-д “Гэм хор учрах буюу түүнээс үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн хэтэрхий болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл нөлөөлсөн бол уг нөхцөл байдлыг харгалзан хариуцах гэм хорын хэмжээг багасгаж болно” гэж заажээ. Тоглоомын эрхийг худалдан авах

³ Иргэний хуулийн 54.1. “Насанд хүрээгүй иргэнтэй хэлцэл хийгч этгээд уг хэлцлийг дэмжсэн зөвшөөрөл олгосноо нотлохыг хууль ёсны төлөөлөгчөөс хүсвэл тэрээр зөвшөөрөх эсэхээ 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ. Энэ тохиолдолд хууль ёсны төлөөлөгчөөс насанд хүрээгүй этгээдэд урьд олгосон зөвшөөрөл буюу татгалзал хүчин төгөлдөр бус болно.”

⁴ ИХ-ийн 54.2. “Энэ хуулийн 54.1-д заасан хугацаанд хариу өгөөгүй бол зөвшөөрөл олгохоос татгалзсан гэж үзнэ.”

⁵ ИХ-ийн 56.1.1. “хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл;”

⁶ ИХ-ийн 492.1.1. “хөрөнгө олж авсан этгээд болон үүрэг гүйцэтгэгч этгээдийн хооронд үүрэг үүсээгүй, эсхүл үүрэг нь хожим дуусгаавар болсон буюу хүчин төгөлдөр бус болсон;”

⁷ ИХ-ийн 497.1. “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.”

⁸ ИХ-ийн 510.1. “Бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх /адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр/ буюу учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлнө.”



болсон үйлдэлд эцэг Х.С-н хүүхдийг хараа хяналтгүй байлгаж, удаан хугацаагаар тоглоом тоглох нөхцөлийг бүрдүүлж, өөрийн өмчлөлийн гар утсыг хүүхдэд шилжүүлсэн, интернэт банкны нууц кодоо хүүхдээс нууцлаагүй зэрэг буруутай үйлдэл нөлөөлсөн нь тогтоогдож байх тул хохирлыг хэмжээг багасгаж хариуцагчаас 12,031,442 төгрөгийг гаргуулж (30,078,605 төгрөгийн 40 хувиар), шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулах боломжтой гэж үзлээ. (14.3)

---o0o---